



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮГИЙН НӨӨЦ ХАНГАГДААГҮЙ
БАЙНА.**

АУДИТЫН КОД: ХЭА-2021/40-ШТА-ГА

“Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-нд ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2024 он



**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар**

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Х.Еркегүл

Утас: 99040507 Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 92116768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Аудитор Б.Ариунаа

Утас: 93032714 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



Аудитыг гүйцэтгэсэн:

Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар

Аудитын менежер
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:
Д.Эрдэнэбилэг
Ц.Билэгсайхан

Аудитор:
Б.Ариунаа
Х.Еркегүл
Т.Алтаншагай

Аудитын тайлан,
дүгнэлт, зөвлөмжтэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах, холбогдох
саналаа өгөхийг хүсвэл
70562112 дугаарын
утсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын
www.open.audit.mn цахим
хуудаснаас үзнэ үү.

Хаяг: Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар

Хэрлэн сум, 4-р баг,
аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл7

БҮЛЭГ 1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих талуудын үйл ажиллагаа хангалтгүй байна.9

1.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хамрагдвал зохих мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулаагүй байна.9

1.2 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын санхүүжилт, хүний нөөц дутагдалтай байна. 12

1.3. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр нөлөөтэй байдлыг үнэлээгүй байна. 18

БҮЛЭГ 2. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хугацаа, вакцины тээвэрлэлт, хадгалалтын горимыг мөрдөөгүй, технологийн хяналт хийхгүй байна.22

2.1. Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын вакцины хадгалалт, тээвэрлэлт стандартын шаардлага хангахгүй байгаа нь вакцины чанарт нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.22

2.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад төлөвлөгөөний дагуу малыг бүрэн хамруулж байгаа ч тарилга товлосон хугацаандаа хийгдэхгүй байна.24

2.3. Дархлаажуулалтын үр дүнгийн хяналтыг хийж байгаа боловч технологийн хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.28

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:32

ДҮГНЭЛТ: 33

ЗӨВЛӨМЖ:34

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 11 дугаар сарын 25

Дугаар А/41

Чингис хот

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан Г
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Мал эмнэлгийн газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, түүний биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

• 232410041

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДХХ	Дотрын халдварт хордлого
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УМЭАЦЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	<i>Малын гоц халдварт өвчний голомт</i>	10
Дүрслэл 2	<i>Мал эмнэлгийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал 1</i>	19
Дүрслэл 3	<i>Мал эмнэлгийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал 2</i>	19
Дүрслэл 4	<i>Мал эмнэлгийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал 3</i>	20
Дүрслэл 5	<i>Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал 1</i>	21
Дүрслэл 6	<i>Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал 2</i>	21
Дүрслэл 7	<i>Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын тооцоо /литр/</i>	22
Дүрслэл 8	<i>Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын тооцоо /м/тун/</i>	23
Дүрслэл 9	<i>Малын гоц халдварт өвчний дархлаажуулалт, өвчний гаралт</i>	26
Дүрслэл 10	<i>Дархлаажуулалтын талаар иргэдээс авсан санал асуулга</i>	26
Дүрслэл 11	<i>Дархлаажуулалтын талаар МЭҮН-ээс авсан санал асуулга</i>	27

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	<i>Мал амьтны халдварт өвчний төрөл</i>	9
Хүснэгт 2	<i>Дархлаажуулалтад хамруулахаар баталсан малын тоо</i>	11
Хүснэгт 3	<i>Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төрөл</i>	11
Хүснэгт 4	<i>Аймгийн МЭГ болон сумдын мал эмнэлгийн тасгийн албан хаагчдын АБТ-д тусгагдсан чиг үүрэг</i>	12
Хүснэгт 5	<i>Аймгийн МЭГ болон сумдын мал эмнэлгийн тасгийн батлагдсан орон тоо</i>	13
Хүснэгт 6	<i>Аймгийн МЭГ болон сумдын мал эмнэлгийн тасгийн хүний нөөцийн судалгаа</i>	13
Хүснэгт 7	<i>МЭҮН-ийн нэг эмчид ногдох малын тоо</i>	14
Хүснэгт 8	<i>Улсын төсвөөс батлагдсан санхүүжилт, хуваарь</i>	16
Хүснэгт 9	<i>Орон нутгийн төсвөөс батлагдсан санхүүжилт, хуваарь</i>	17
Хүснэгт 10	<i>Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	27
Хүснэгт 11	<i>МЭГ-аас гүйцэтгэлийн хяналтын төлөвлөгөө, тайлан</i>	29
Хүснэгт 12	<i>Үр дүнгийн хяналтын судалгаа</i>	30

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.</p>
Аудитын зорилт	<p>“Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.</p> <p>Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах тогтолцоо бүрдсэн эсэх,• Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин нь хугацаандаа нийлүүлэгдэн хийгдэж, үр дүнг хянаж байгаа эсэх,
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитад Хэнтий аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар түүний хэлтсүүд, Мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлгийн тасаг зэрэг төрийн байгууллагууд, мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн аж ахуйн нэгжүүд болон холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.</p>
Аудитын хязгаарлалт	<p>Аймгийн малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд аудит хийсэн бөгөөд МЭЭГ-ын үйл ажиллагаа хамрагдаагүй болно.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулав. Үүнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, түүвэрлэн баримт материал нягтлан шалгах зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын загварын матриц, хөтөлбөрийн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>

Аудитын хугацаа	Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрөөс 7 дугаар сарын 31-ний хооронд хэрэгжүүлж, аудитын талбарын ажлыг 9 дүгээр сарын 06-аас эхлүүлэн, аудитын тайлагналын үе шатыг 11 дүгээр сарын 18-ны дотор Тэргүүлэх аудиторын тушаалаар Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүлнэ.
Хүндрэл бэрхшээл	Аудитыг гүйцэтгэхэд бэрхшээл гарлаа Үүнд: Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын хугацаа хойшилсноор тус аудиттай хугацааны хувьд давхцал үүссэн.

БҮЛЭГ 1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих талуудын үйл ажиллагаа хангалтгүй байна.

1.1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хамрагдвал зохих мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулаагүй байна.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн Бүсчилсэн хөгжлийн 8.1.3-д “...малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болгоно” зорилттой нийцүүлэн Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.3.5-д /Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, малаас хүнд дамжих халдварт болон гоц халдварт өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаална/ 1 зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4-т /Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулна/ 1 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 3 арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна.

Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 1 зорилт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 1 зорилт, 2 арга хэмжээний суурь түвшнийг тодорхойлсон боловч хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлоогүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хэмжигдэхүйц, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан байх заалттай нийцэхгүй байна.

Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд 21 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Стратеги төлөвлөгөөний 19-д Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг даган гарах 19 эрх зүйн баримт бичгийг боловсруулан батлуулах, 20-д заасан жилд 3-аас доошгүй суманд лаборатори байгуулах зорилтуудын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүйгээс биелэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолоор Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний олон улсын болон дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчний төрлийг тогтоосон байна.


Хүснэгт 1: Мал, амьтны халдварт өвчний төрөл

Д/д	Мал, амьтны халдварт өвчний төрөл	Өвчний төрөл тоогоор	Хэнтий аймагт гарсан өвчний төрөл
1	Гоц халдварт, халдварт, Зооноз өвчин /олон улсын худалдаанд хориг саад үүсгэдэг/	18	8
2	Гоц халдварт, халдварт өвчин /Дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг/	27	4
3	Бусад халдварт өвчин	23	2
	Нийт	68	14

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021-2023 оны мэдээ

Тус аймагт гарсан малын гоц халдварт, халдварт өвчний тохиолдлын голомтын судалгааг сүүлийн 4 жилийн байдлаар авч үзэхэд:

Дүрслэл 1: Малын гоц халдварт болон халдварт өвчний голомт



* Эх сурвалж: Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021-2023 оны малын өвчний мэдээ

Үүнээс үзэхэд малын халдварт өвчний гаралт буурч, гоц халдварт өвчний гаралт өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь өвчний гаралт буурсан байх зорилт бүрэн хангагдахгүй байгааг харуулж байна.

Иймд аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг, байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан хэмжигдэхүйц, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтээр хангагдсан байх шаардлагад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллах хүний нөөцийг мэргэшүүлэх шаардлагатай байна.

Хэнтий аймагт 2021-2023 онд шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах 4 төрлийн гоц халдварт, боом, галзуу, бруцеллёз, листериоз 4 төрлийн малаас хүнд халдварладаг зооноз, цусан халдвар, дуут хавдар, дотрын халдварт хордлого, гахайн цусан халдвар зэрэг халдварт 4 өвчин бүртгэгджээ.

Аймгийн хэмжээнд 2021-2023 онд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулахаар Мал эмнэлгийн ерөнхий газар болон аймгийн Засаг даргад хүргүүлсэн саналыг батлагдсан малын тоотой харьцуулан үзлээ.

Дархлаажуулалтад хамрагдвал зохих малыг аймгийн Мал эмнэлгийн газраас өвчний төрөл тус бүрээр гарган хүргүүлдэг ч Мал эмнэлгийн ерөнхий газар малын тоог хасаж баталж байгаа нь мал, амьтны халдварт өвчин гарах эрсдэлтэй нөхцөл үүсэх магадлалтай байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааварт тусгагдсанаар эдгээр 12 халдварт, гоц халдварт өвчний дархлаажуулалтад аймгийн хэмжээнд хамрагдвал зохих мал, амьтныг 2021-2023 оны жилийн эцсийн малын дүнгээр тооцож үзвэл:

Хүснэгт 2: Дархлаажуулалтад хамруулахаар баталсан малын тоо /мянган толгой/

№	Халдварт өвчин	Хамрагдвал зохих малын тоо			МЭГ санал			Батлагдсан		
		2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
1	Бог малын мялзан	4196.9	4261	3632.8	1993.9	1885.2	2022.3	207.0	64.6	1425.8
2	Шүлхий	4604.0	4695.8	4038.5	4538.7	6359.6	5898.7	1613.7	957.5	929.8
3	Хонины цэцэг өвчин	2546.5	2610.8	2266.3	1188.9	1130.1	1242.7	598.3	1457.9	1126.2
4	Үхрийн арьс товруутах	407.1	434.8	405.7			531.7	24.2	212.2	
5	Листериоз			3632.8						10.0
6	Бруцелёз	4604.0	4695.8	4038.4	1064.1	1069.6	1088.9	1385.1	1126.7	1286.7
7	Боом	4955.0	5076.6	4400.5	345.2	270.4	130.0	225.8	118.2	130.0
8	Галзуу	4955.0	5076.6	4400.5	286.6	231.8	104.3	200.2	84.3	55.0
9	Цусан халдвар	4950.8	5072.4	4396.6	369.1	334.2	318.0	180.6	326.0	213.0
10	Дуут хавдар	407.1	434.8	405.7	123.4	127.4	117.8	70.2	91.2	90.4
11	ДХХ	2546.5	2610.8	2266.3	277.0	272.6	288.6	222.0	222.0	290.0
12	Гахайн цусан халдвар	1.073	1.501	1.152	1.6	1.2	2.0	1.0	1.8	1.6
Нийт		34174.0	36992.9	35908.3	10188.5	11682.1	11745.0	4728.1	4662.4	5558.5

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021-2023 оны санал, МЭЭГ-ын даргын тушаал

Хүснэгт 3: Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдвал зохих малын төрөл

	Халдварт өвчний төрөл	Үхэр	Хонь	Ямаа	Адуу	Тэмээ	Гахай
1	Шүлхий						
2	Бог малын мялзан						
3	Хонины цэцэг өвчин						
4	Үхрийн арьс товруутах						
5	Боом						
6	Галзуу						
7	Бруцеллёз						
8	Листериоз						
9	Цусан халдвар						
10	Дуут хавдар						
11	Дотрын халдварт хордлого						
12	Гахайн цусан халдвар						

*Эх сурвалж: МЭЭГ-ын даргын тушаалаар баталсан тэмцэх заавар аргачлалууд

Хамрагдвал зохих мал, амьтныг урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтад бүрэн хамруулбал малын халдварт өвчингүй эрүүл бүс бий болж урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт хангагдах боломжтой юм.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь оторлох, тууварлах мал сүрэгт эмнэл зүйн үзлэг хийж эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх батлагдсан дархлаажуулалтыг хийн ажиллаж байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын жилийн төлөвлөгөө боловсруулж түүний хүрээнд мал эмнэлгийн ажил үйлчилгээний хамтран ажиллах гурвалсан гэрээг мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй байгуулан эмчлэн сэргийлэх арга хэмжээний захиалгыг авч захиалгын хүрээнд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд аймгийн мал эмнэлгийн газарт 16, мал эмнэлгийн улсын байцаагчид 15, мал эмнэлгийн тасагт 9, аймгийн мал эмнэлгийн лабораторид 6, сумын Засаг даргад 10, аймгийн Засаг даргад 4 чиг үүргийг тусгасан байна.

Хүснэгт 4: Аймгийн мал эмнэлгийн газар болон сумдын малын эмнэлгийн тасгийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусгасан зорилт, чиг үүргийг тоогоор харуулбал.

№	Албан тушаал	Зорилт	Чиг үүрэг
1	Мал, амьтны эрүүл мэндийн албаны дарга	4	22
2	Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч	3	21
3	Зооноз, халдварт өвчин, тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн	4	22
4	Өвчний мэдээ, тайлан, цахим бүртгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	4	21
5	Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж дотоод хяналт, шилжилт хөдөлгөөн, баталгаажуулалт, эмийн хяналт хариуцсан улсын ахлах байцаагч	4	26
6	Шимэгчтэх, халдваргүй өвчин, малын эм, био бэлдмэлийн хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтэн	4	18
7	Сумын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч	5	21
8	Сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч	5	21

* Эх сурвалж: Батлагдсан албан тушаалын тодорхойлолт

Хуульд заасан чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж өгсөн боловч хяналтын болон бүртгэл мэдээллийн зарим чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

1.2 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын санхүүжилт, хүний нөөц дутагдалтай байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.81-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор “Сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийг сумын хөдөө аж ахуйн тасаг болгон өөрчилж, мал эмнэлгийн тасгийг шинээр байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлог, ажлын ачааллыг харгалзан орон тооны дээд хязгаарыг хөдөө аж ахуйн тасагт 3, мал эмнэлгийн тасагт 2” байхаар тус тус тогтоосон байна.

1 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулахаар төлөвлөсөн малыг бүрэн хамруулж байгаа ч дархлаажуулалтын хугацааны давхцал, багийн Засаг даргын хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлэхгүй байгаагаас зарим халдварт өвчний дархлаажуулалт төвлөсөн хугацаандаа хийгдэхгүй байна.

Хүснэгт 5: Аймгийн МЭГ болон сумдын мал эмнэлгийн тасгийн батлагдсан орон тоо

№	МЭГ-ын бүтэц, орон тооны нэр	2021		2022		2023	
		МЭГ	Сумд	МЭГ	Сумд	МЭГ	Сумд
1	Засгийн газрын 267-р тогтоолоор		36		36		36
2	ХХААХҮ-ын сайдын 2021 А/13, 2022 А/24, 2023 А/17 тушаалаар	17	36	17	36	18	36

* Эх сурвалж: ЗГ-ын тогтоол, ХХААХҮ-ийн сайдын тушаал

Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг орон тоо, төсөв, ашиглаж буй компьютер техник, хэрэгслийн хамт одоо эрхэлж байгаа чиг үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д заасан байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн мал эмнэлгийн газарт мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг шилжүүлэн ажилласан байна.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д2 заасан бүтцийн дагуу Хэнтий аймагт мал эмнэлгийн үйлчилгээг аймгийн Мал эмнэлгийн газар, 18 сумын мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн 71 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газар болон сумдын мал эмнэлгийн тасагт 2021 онд 77.3 хувь буюу 12 хүн дутуу, 2022 онд 75.5 хувь буюу 13 хүн дутуу, 2023 онд 72.3 хувь буюу 15 орон тоо дутуу ажиллаж байгаагаас 2021-2023 онд сумын мал эмнэлгийн тасагт батлагдсан орон тооноос 11-13 хүн дутуу буюу 63.9-69.4 хувь нь ажиллаж байна.

Хүснэгт 6: МЭГ болон сумдын мал эмнэлгийн тасгийн хүний нөөцийн судалгаа

Хүний нөөц	2021 он		2022		2023	
	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэл
Мал, амьтны эрүүл мэндийн алба	5	5	5	4	6	5
Лаборатори	5	5	5	4	5	4
Захиргаа, санхүүгийн алба	7	7	7	7	7	7
Мал эмнэлгийн газрын орон тоо	17	17	17	15	18	16
Сумдын мал эмнэлгийн тасгийн орон тоо /18 сум/	36	24	36	25	36	23
Нийт	53	41	53	40	54	39

* Эх сурвалж: ЗГ-ын тогтоол, ХХААХҮ-ийн сайдын тушаал

Аймгийн Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн алба болон лабораторийн мэргэжилтнүүд нь тогтвор суурьшилтай 3-20 жил ажилласан, мэргэжлийн шаардлага хангасан боловсон хүчнээр хангагдсан байна.

2 “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ”

Аймгийн хэмжээнд сумын Мал эмнэлгийн тасагт нийтдээ 36 орон тоотой ажиллахаас 2021 онд 12, 2022 онд 11, 2023 онд 13 орон тоо нөхөгдөөгүйн 10 тархвар зүйч байна.

Сумын мал эмнэлгийн тасагт улсын байцаагч 1, тархвар зүйч 1 орон тоо батлагдсан боловч гүйцэтгэлээр 2021 онд 24, 2022 онд 25, 2023 онд 23 орон тоогоор ажиллаж, дунджаар 12 орон тоо сул байгаа нь мал, амьтныг эрүүлжүүлэх үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй болсныг харуулж байна.

Үүнийг албан тушаалын ангиллаар авч үзвэл:

Нийт 8 сумын мал эмнэлгийн тасаг батлагдсан орон тоогоор ажиллаж байгаа бол 5 сумын тархвар зүйчийн ажлыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч давхар хавсран гүйцэтгэж, улсын байцаагчтай ч тархвар зүйчээ хавсардаггүй 2 сум, улсын байцаагч, тархвар зүйч байхгүй 3 сум байна. Тухайлбал:

Хэрлэн, Дадал сумдад тархвар зүйчийн орон тоо нөхөгдөөгүй бол Баянмөнх, Дархан, Мөрөн сумын мал эмнэлгийн тасагт улсын байцаагч, тархвар зүйч байхгүйгээс аймгийн Мал эмнэлгийн газрын мал, амьтны эрүүл мэндийн албаны мэргэжилтнүүд хавсран ажиллаж байна.

Суманд тархвар зүйчийн орон тооны ажиллах хүч 2021, 2022 онд 38.8 хувь, 2023 онд 55.5 хувийн дутагдалтай байгаа нь мал, амьтны тархвар зүйн судалгаа хийх, малын гаралтай өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх бодлогыг сум орон нутагт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн нэг малын эмчийн хариуцах малын тоог Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартын 7.1.3-д3 зааснаас 2.1-ээс 2.3 дахин их буюу дунджаар 83.7-аас 91.8 мянган мал ногдож мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмчийн ажлын ачаалал нэмэгдэж байна.

Хүснэгт 7: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 1 эмчид ногдох малын тоо

Хамрах он	МЭҮН-ийн тоо	Ажиллаж буй малын эмчийн тоо	Малын тоо /хонин толгойд шилжүүлсэн мянган толгой/	Нэг малын эмчид ногдож буй малын дундаж тоо	Стандартаар шаардлагатай малын эмчийн тоо	Ачаалал
2021 он	71	104	8,922.7	85.8	223	2.1
2022 он	75	102	9,361.8	91.8	234	2.3
2023 он	71	101	8,458.3	83.7	211	2.1

* Эх сурвалж: Аймгийн Мал эмнэлгийн газрын судалгаа

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартаар 2021-2023 онд 211-234 малын эмч ажиллах шаардлагатай байхад 2021 онд 104, 2022 онд 102, 2023 онд 101 малын эмч ажилласан байна.

Үүнийг дээрх стандарттай харьцуулахад 2021 онд 119, 2022 онд 132, 2023 онд 110 малын эмчийн мэргэжилтэй хүний нөөцийн дутагдалтай байна.

Тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн 76-85 хувь нь нэг малын эмчийн хариуцах малын тоог тогтоосон стандартын

3 "Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх үед нэг малын эмчийн хариуцах малын тоо хонин толгойд шилжүүлснээр дөчин мянга (40.000)-аас ихгүй байна"

шаардлагыг баримталж ажиллахгүй байгаагаас зарим аж ахуйн нэгжүүдийн нэг малын эмчид хэт өндөр буюу 100.0-329.9 мянган мал ногдож байна. Тухайлбал:

Нэг малын эмч 2021 онд 100.0-159.9 мянган малыг хариуцаж буй 20 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, 2022 онд 100.0-329.9 мянган мал хариуцаж буй 18 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, 2023 онд 100.0-288.2 мянган мал хариуцаж буй 24 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368:2018 стандартад заасан нэг малын эмчид ногдох малын тоог 2021-2023 онд 11-18 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хангасан бол 55-60 үйлчилгээний нэгж стандартын шаардлагыг мөрдөж ажиллаагүй байна. Эдгээрийг оноор харуулбал:

- 2021 онд нийт 71 МЭҮН-ийн 16 нь стандартын шаардлагыг мөрдөж ажилласан, 55 буюу 77 хувь нь мөрдөөгүй,
- 2022 онд нийт 75 МЭҮН-ийн 18 нь стандартын шаардлагыг мөрдөж ажилласан, 57 буюу 76 хувь нь мөрдөөгүй.
- 2023 онд нийт 71 МЭҮН-ийн 11 нь стандартын шаардлагыг мөрдөж ажилласан, 60 буюу 85 хувь нь мөрдөөгүй байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой хүний нөөц Хэнтий аймгийн хэмжээнд хомсдолтой байгаа нь сумын мал эмнэлгийн тасаг болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд нөлөөлж хүний нөөц дутагдсан байна. Тухайлбал:

- Аймгийн МЭГ-аас гаргасан Хэнтий аймгийн малын эмч нарын судалгаагаар нийт 198 малын эмчийн мэргэжилтэй хүний нөөцийг насны бүтцээр ангилбал 58 нь тэтгэврийн насны, 140 нь хөдөлмөрийн насны ажиллах хүч эзэлж байна.
- Нийт малын эмч мэргэжилтэй хүний нөөцийн 135 нь мэргэжлийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа бол 12 нь тэтгэвэрт, 51 нь мэргэжлээрээ ажиллахгүй байна.

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн бүсчилсэн хөгжилд тусгасан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, үйлдвэр технологийн парк байгуулан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох зорилгод хүрэхийн тулд Хэнтий аймагт голомтлон гарсан улсын төсвөөс санхүүждэг 7, орон нутгийн төсвөөс санхүүждэг 4 төрлийн малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт хамрагдвал зохих малыг бүрэн хамруулах шаардлагатай байна. Үүнээс:

Улсын төсвөөс санхүүжүүлэх 7 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт /давхардсан тоогоор/ 23,182.6 мянган малыг хамруулахад 10,182.3 сая төгрөгийн вакцин, 7,057.5 сая төгрөгийн үйлчилгээний зардал нийт 17,239.8 сая төгрөгийн санхүүгийн нөөц шаардагдахаар байна.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээр давхардсан тоогоор 2021 онд 4,257.5 мянган малыг хамруулж 1,807.0 сая төгрөг, 2022 онд 4,021.4 мянган малыг хамруулж 2,393.7 сая төгрөг, 2023 онд 4,986.2 мянган малыг хамруулж 3,096.1 сая төгрөгийн вакцин, үйлчилгээний зардал олгосон байна.

Энэ нь дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт малын 20.9 хувийг хамруулах вакцин болон үйлчилгээний зардал байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 4 төрлийн халдварт өвчний урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор нийт 7,073.7 мянган малыг хамруулж вакцинд 3,281.9 сая төгрөг, үйлчилгээний зардалд 3,824.2 сая төгрөг, нийт 7,106.1 сая төгрөгийн санхүүгийн нөөц шаардлагатай байна. Үүнээс 2023 онд 591.1 мянган малыг хамруулж вакцинд 215.3 сая төгрөг, үйлчилгээний зардалд 324.2 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт малын 8.4 хувийг хамруулсан нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц хангагдаагүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалттай холбоотой санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв, иргэн, хуулийн этгээдийн эх үүсвэрээс шийдвэрлэхээр заасан.

Аймгийн Мал эмнэлгийн газраас төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтын ажилд шаардагдах вакцин болон тарилгын үйлчилгээний зардлын санхүүжилтийг 2021 онд 20,531.1 мянган малыг хамруулахаар 10,884.4 сая төгрөг, 2022 онд 17,353.5 мянган малыг хамруулахаар 5,135.6 сая төгрөгийн вакцин, 4,521.9 сая төгрөгийн үйлчилгээний зардал, 2023 онд 17,905.4 мянган малыг хамруулахаар 6,536.2 сая төгрөгийн вакцин, 4,742.1 сая төгрөгийн тарилгын үйлчилгээний зардал төлөвлөж Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 8: Улсын төсвөөс малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд шаардагдах санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэл

Д/д	Хамрах он	Төлөвлөлт			Гүйцэтгэл		
		Хамруулах малын тоо /мянган толгой/	Вакцины зардал /сая төгрөг/	Тарилгын үйлчилгээний зардал /сая төгрөг/	Хамруулсан малын тоо /мянган толгой/	Вакцины зардал /сая төгрөг/	Тарилгын үйлчилгээний зардал /сая төгрөг/
1	2021	20,531.1	10,884.4	0	4,309.5	1,379.9	668.4
2	2022	17,353.5	5,135.6	4,521.9	3,950.4	1,180.6	1,213.7
3	2023	17,905.4	6,536.2	4,742.1	4,845.1	1,690.1	1,390.3

* Эх сурвалж: Аймгийн Мал эмнэлгийн газрын судалгаа

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцины зардлыг төлөвлөж хүргүүлснээс 2021 онд 10.5 хувь, 2022 онд 23.0 хувь, 2023 онд 26.1 хувийг хуваарилж олгон, нийт урьдчилан сэргийлэх тарилгад хамруулахаар төлөвлөсөн малын 20.9-27.0 хувийг хамруулж байна.

Дархлаажуулалтын вакцины зардлыг тогтмол өсгөснөөр малыг эрүүлжүүлж, эрүүл бүс бий болгох урт хугацааны бодлогын зорилтын хэрэгжилтэд сайнаар нөлөөлөхөөр байна.

Улсын төсвөөс малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардагдах үйлчилгээний зардлыг гоц халдварт өвчний тархалтаас хамаарч дархлаажуулалтад хамрагдах мал, амьтны тоог гарган МЭЕГ-т хүргүүлж, хамруулсан малын тоогоор санхүүжилтээ бүрэн авсан байна.

Аймгийн мал эмнэлгийн газраас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний зардалд 2022 онд 4,521.9 сая төгрөг, 2023 онд 4,742.1 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөж МЭЕГ-т хүргүүлсэн байна. Гүйцэтгэлээр дархлаажуулалтын үйлчилгээний зардалд 2021 онд 4,309.5 мянган малыг хамруулж 668.4 сая төгрөг, 2022 онд

3,950.4 мянган малыг хамруулж 1,213.7 сая төгрөг, 2023 онд 4,845.1 мянган малыг хамруулж 1,390.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилтийг жил бүр төсөвт тусган баталж байна. Төсвийн төслөөр урьдчилан сэргийлэх дархлаажуулахад шаардлагатай төсвийг 2021 онд 771.1 мянган малд 795.7 сая төгрөг, 2022 онд 859.8 мянган малд 700.5 сая төгрөг, 2023 онд 726.4 мянган малд 605.1 сая төгрөг байхаар төсөвлөж аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Хүснэгт 9: Орон нутгийн төсвөөс малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд шаардагдах санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэл

сая.төгрөг

Д/д	Хамрах он	Төлөвлөлт		Баталсан		Гүйцэтгэл	
		Хамруулах малын тоо /мянган толгой/	Санхүүжилт	Хамруулах малын тоо /мянган толгой/	Санхүүжилт	Хамруулсан малын тоо /мянган толгой/	Санхүүжилт
1	2021	771.1	795.7	472.3	452.9	472.3	452.8
2	2022	859.8	700.5	641.0	542.8	636.0	538.5
3	2023	726.4	605.1	593.4	539.7	591.1	539.7

* Эх сурвалж: Аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн тайлан

Харин орон нутгийн төсвөөс малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зардлыг 2021 онд 66.8 хувь, 2022 онд 80.4 хувь, 2023 онд 96.3 хувиар баталж олгосон нь халдварт өвчний гаралтыг бууруулахад нөлөөлсөн байна.

Улсын төсвөөс малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын санхүүждэг үйлчилгээний зардлын нормативыг 2021 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2017 оны А-112 дугаар тушаалаар баталсан нормативыг үндэслэн бод малыг 200 төгрөг, бог малыг 150 төгрөгөөр тооцож, орон нутгийн төсвөөс санхүүждэг үйлчилгээний зардлын нормативыг 2021 онд аймгийн ИТХ-ын 2013 оны 49 тогтоолоор батлагдсан “Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний төлбөр, үнэлгээний норматив”-ыг үндэслэн бод малын 450 төгрөг, бог малыг 400 төгрөгөөр тооцсон байна.

Улмаар 2022-2023 онд Сангийн Сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ний өдрийн 118, А-201 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив”-ын 1.1.14, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг 1.1.25-д зааснаар тооцож олгожээ.

Дээрх нормативыг үндэслэн Улсын төсвөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний зардалд 2021 онд 668.4 мянган төгрөг, 2022 онд 1,213.7 сая төгрөг, 2023 онд 1,390.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Үүнээс тарилгын үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг 2021 онд 104.5 сая төгрөг, 2022 онд 543.8 сая төгрөгийг тус тус он дамжуулан олгосон байна.

Мал эмнэлгийн ерөнхий газраас 2021 онд 1,138.1 сая төгрөгийн вакцин хүлээж авч 1,379.9 сая төгрөгийн вакцин зарцуулсан, 2022 онд 1,198.0 сая төгрөгийн вакцин хүлээж

4 1.1.1. Улсын төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний зардлын нормативын бод мал болон амьтныг 400 төгрөг, бог малыг 250 төгрөгөөр тооцож,

5 1.1.2-д бод мал, амьтныг 450 төгрөг, бог мал, шувууг 200 төгрөгөөр тооцож,

авч 1,180.6 сая төгрөгийн вакцин зарцуулсан, 2023 онд 1,673.5 сая төгрөгийн вакцин зарцуулж, жилийн эцэст 21.0 сая төгрөгийн вакцины нөөцтэй байна.

Хамрагдвал зохих малын тоо, норм, хэвийн хорогдлоо тооцож олгосон вакцин, тарилгын үйлчилгээний хөлсийг анхан шатны баримттай тулган шалгахад зориулалтын дагуу олгосон байна.

1.3. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр нөлөөтэй байдлыг үнэлээгүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2024 онд Мал эмнэлгийн газарт хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд өгсөн дүгнэлт, зөвлөмжөөс үзэхэд үр дүн нь зөвхөн бодлогын баримт бичиг болон байгууллагын төлөвлөгөө хэрхэн уялдаж байгаад чиглэсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох журмын зааснаар бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг үнэлж, цаашид арга хэмжээг үр, дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах талаар дүгнэлт, зөвлөмжийг өгөөгүй байна.


Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.1-т зааснаар баримт бичгийн төлөвлөлт, биелэлт, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ, үр нөлөөг үнэлж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээг авах талаар зөвлөмжийг хүргүүлж ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар мал эмнэлгийн үйлчилгээний 72 нэгж үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу оторлох, тууварлах мал сүрэгт эмнэл зүйн үзлэг хийж эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг хийх зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ дундаас малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгатай холбоотой асуудлаар Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж болон малчин өрхөөс асуумжийг авч ажиллалаа. Асуумжид 55 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, 148 малчин өрх хамрагдсан.

Малчин өрх: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тарилга хийхтэй холбоотой хүндрэлтэй асуудал гардаг эсэхэд нийт асуумжид оролцсон малчин өрхийн 40.5 хувь ямар нэгэн хүндрэл байхгүй гэж хариулсан байна. Харин тухайн малчин өрхийн малыг тарилгүй үлдээдэг гэж 13.9 хувь, мэргэжлийн бус хүнээр тарилга хийлгэдэг гэж 10.4 хувь нь хариулсан бол вакцины үр дүн муу байдаг гэж 9.2 хувь нь хариулжээ.

Дүрслэл 2: Мал эмнэлгийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал1



* Эх сурвалж: Малчин иргэдээс авсан санал асуулга

Малын дуудлага үйлчилгээтэй холбоотой хүндрэлтэй байдлын талаар цаг хугацаандаа ирж үйлчилгээ үзүүлдэг гэж 31.5 хувь нь хариулсан бол хугацаа алдаж ирдэг, ирэхдээ эм бэлдмэл, багаж хэрэгсэлгүй ирдэг гэж 29.8 хувь, дуудлага өгөхөд ирдэггүй гэж 17.4 хувь нь хариулжээ. Өгсөн дуудлагын дагуу утсаар эмчилгээний заавар зөвлөгөөг өгдөг гэж 20.2 хувь нь хариулсан байна.


Дүрслэл 3: Мал эмнэлгийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал2



* Эх сурвалж: Малчин иргэдээс авсан санал асуулга

Малын халдварт болон гоц халдварт өвчин гарсан үед ямар нэгэн хүндрэлтэй асуудал гардаггүй гэж 61.6 хувь нь хариулсан бол хугацаа алдаж ирдэг гэж 23.3 хувь, дуудлагаар ирэхдээ эм бэлдмэл, багаж хэрэгсэлгүй ирдэг гэж 13.8 хувь нь хариулжээ.

Дүрслэл 4: Мал эмнэлгийн үйлчилгээний талаар иргэдээс авсан санал 3




* Эх сурвалж: Малчин иргэдээс авсан санал асуулга

Асуумж, судалгаанаас авч үзэхэд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээг үзүүлдэг боловч боловсон хүчний бэлэн байдал, шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт, ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалан үйлчилгээг бүрэн үзүүлэхгүй байгаа нь тарилгын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх, гоц халдварт, халдварт өвчин гарсан үед хугацаа алдаж арга хэмжээ авснаас шалтгаалан өвчний тархалт нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газраас “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-ын /MNS 5368-2018/ / хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж, хугацаатай үүрэг чиглэл өгөх, биелэлтийг хангуулж ажиллах, хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн МЭҮН-ийн гэрээг цуцлах, улсын төсвөөс олгох ажил үйлчилгээний хөлсийг бууруулах замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, стандартыг хангуулж ажиллах шаардлагатай байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйлчилгээ үзүүлэхэд малчдын зүгээс хүндрэлтэй ямар асуудлууд үүсдэг талаар асуумжийг дүгнэж үзвэл урьдчилан сэргийлэх тарилгын ажлыг гүйцэтгэхэд малчид малаа товлосон хугацаанд бэлэн байлгадаггүй, барьж бэхэлдэггүй, тарилгын хашаа, хоолой бэлэн бус, малчин өрхийн баталгааны тэмдэг, малын эрүүл мэндийн дэвтэр байхгүй зэрэг асуудал нийт 98.1 хувийг эзэлж байна.


Дүрслэл 5: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал асуулга 1



* Эх сурвалж: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал асуулга

Мөн гоц халдварт өвчний үед малын өвчлөлийн талаар дуудлагыг хугацаа алдаж өгдөг, өөрсдөө дур мэдэж эмчилгээ хийдэг, өвчилсөн малаа устгуулдаггүй зэрэг асуудлууд гаргадаг гэж 83.9 хувьд хариулсан бол өвчний талаар дуудлага өгдөггүй гэж 10.5 хувь нь хариулсан байна.

Дүрслэл 6: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал асуулга 2



* Эх сурвалж: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал асуулга

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх хугацааны талаар мэдээллийг багийн Засаг дарга малчдад хүргэх үүрэгтэй боловч судалгааны дүнгээс үзэхэд 63.6 хувь нь энэхүү үүргээ бүрэн биелүүлдэггүй гэж үзжээ.

Мэдээлэл хүрээгүйгээс малчид товлосон хугацаанд малаа бэлэн байлгахгүй, тарилгын хашаа, хоолой бэлэн бус байх, малчин өрхийн баталгааны тэмдэг, малын эрүүл мэндийн дэвтрийн бэлэн байдлыг хангахгүй байх болон малчдын хайхрамжгүй, хариуцлагагүй байдал нь дархлаажуулалт хийх хугацаанд нөлөөлж байна.

Мал эмнэлгийн газар, сумдын Мал эмнэлгийн тасгаас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар малчдын хүлээх эрх, үүргийн талаар малчдад танилцуулах, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар сануулах, мөн багийн Засаг даргын хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжилтийг хангуулах, хариуцлагын асуудлыг сумын Засаг даргатай байгуулах гэрээнд тусгайлан оруулах талаар санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хугацаа, вакцины тээвэрлэлт, хадгалалтын горимыг мөрдөөгүй, технологийн хяналт хийхгүй байна.

2.1. Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын вакцины хадгалалт, тээвэрлэлт стандартын шаардлага хангахгүй байгаа нь вакцины чанарт нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолд тусгагдсан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 36 дугаар зүйлийн 36.1⁶ заалтыг мөрдөн Биокомбинат ТӨХХК болон аймгийн Засаг даргатай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулж бэлтгэн нийлүүлсэн байна.

Харин Монгол улсад үйлдвэрлэх боломжгүй гоц халдварт өвчний вакцины худалдан авах ажиллагааг Мал эмнэлгийн ерөнхий газар хариуцан, орон нутагт нийлүүлсэн урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг аймаг, сумын мал эмнэлгийн газар, тасгууд зохион байгуулж, дархлаажуулалтыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд гүйцэтгэсэн байна.

Хэнтий аймагт 2021-2023 онд Биокомбинат ТӨХХК-тай 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн №2021/01/22 тоот гэрээгээр 154,3 сая төгрөгийн 4 төрлийн өвчний эсрэг 7,342.1 литр вакцин, 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн №2022/02/22 тоот гэрээгээр 195,9 сая төгрөгийн 4 төрлийн өвчний эсрэг 6,252.0 литр вакцин, 2023 оны 2 дугаар сарын 14-ний №2023/02/21 тоот гэрээгээр 215,4 сая төгрөгийн 4 төрлийн 5,255.8 литр малын халдварт өвчний эсрэг вакциныг худалдан авах гэрээ байгуулсан байна.

Дүрслэл 7: Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын вакцины тооцоо




* Эх сурвалж: Хэнтий аймгийн МЭГ-аас захиалсан вакцины тооцоо

⁶ 36.1.Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно:
36.1.1.оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч, эсхүл түүнээс лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны нэг этгээд гүйцэтгэх боломжтой бол;

Хэнтий аймгийн хэмжээнд малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар болон Биокомбинат ТӨХХК-аас 2021 онд 4,427.6 литр, 4,377.0 мянган тун вакцин, 2022 онд 6,355.4 литр, 4,139.8 мянган тун вакцин, 2023 онд 5,465.8 литр 4,623.7 мянган тун вакциныг аймгийн төв хүртэл вакцины зааварт тусгагдсан хөргүүртэй, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн байна.

Дүрслэл 8: Малын халдварт өвчний эсрэг дархлаажуулалтын вакцины тооцоо



*Эх сурвалж: Хэнтий аймгийн МЭГ-аас захиалсан вакцины тооцоо

Аймгийн Мал эмнэлгийн газарт 2021-2023 онд нийлүүлсэн вакцинуудаас 2023 онд дотрын халдварт хордлого, энтеробактериоз өвчний эсрэг 1,206.0 литр вакцин “Биокомбинат” ТӨХХК-ний үйлдвэрлэлийн процессоос хамаарч нийлүүлэлт хойшлогдон дархлаажуулалтын хугацаанаас 2 сараар хоцорч ирсэн байна.

Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахдаа “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.12⁷ дахь хэсэгт заасныг үндэслэн аймгийн МЭГ, сумын ЗДТГ болон мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн хооронд гурвалсан гэрээ байгуулдаг зохицуулалттай байна.

Харин 2021 онд гарсан “Ковид-19” өвчний үед гэрээ байгуулагдаагүй 2020 онд үйлчилгээ эрхэлж байсан 70 аж ахуйн нэгжүүдээр шууд гүйцэтгүүлж, 2022 онд 77, 2023 онд 71 аж ахуйн нэгжтэй гурвалсан гэрээ байгуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна.

Аймгийн МЭГ, сумын ЗДТГ болон Мал эмнэлгийн үйлчилгээг эрхлэгч ААН-үүд вакцины зааварт тусгасан шаардлагыг хангасан хөргүүртэй тээврийн хэрэгслээр

⁷ 30.12. Сум, дүүргийн Засаг дарга, мал эмнэлгийн тасаг, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж энэ хуулийн 28.2-т заасан байгууллагын даргын баталсан загварын дагуу гурвалсан гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлнэ.

хангагдаагүйгээс Чингис хотоос сумын төв хүртэл вакциныг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн нь вакцины чанар алдагдаж, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

Тээвэрлэлтийн горим алдагдаж байгаа нь "Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5368:2018 стандартын 8.1.5-д "Эм, био бэлдмэл, вакциныг зааврын дагуу тээвэрлэх, хадгалах, зарцуулах бөгөөд эм бэлдмэл хэрэглэсэн тухай бүрд мал, амьтны эрүүл мэндийн дэвтэрт бичиж тэмдэглэнэ" гэсэн заалт мөрдөгдөхгүй нөхцөлийг үүсгэж байна.

Аймгийн төвөөс сум хүртэл 2021 онд 4,398.2 литр, 3,444.9 мянган тун вакцин, 2022 онд 6,347.2 литр, 3,821.4 мянган тун вакцин, 2023 онд 5,463.6 литр 4,531.4 мянган тун вакцины тээвэрлэлтийг суудлын зориулалттай, ердийн тээврийн хэрэгслээр тээвэрлэжээ.

Аймгийн Мал эмнэлгийн газар малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакциныг зааварт тусгагдсан шаардлагыг хангасан өрөө, -21-ээс -86 градуст хадгалах хөргүүрээр хангагдсан байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай 2021-2023 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин хадгалах зориулалтын өрөөг 16 сум шийдвэрлээгүй нь вакцины чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэл байна.

Харин Батноров, Цэнхэрмандал сумдад вакцин хадгалах өрөө болон хөргөгчийг шийдвэрлэсэн нь вакцины чанар хадгалагдах сайн жишгийг бусдадаа үзүүлж байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцины 25 суурин, 79 зөөврийн хөргүүрээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд хангагдсаны 64 зөөврийн хөргүүрийг орон нутгийн төсвийн 9,6 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авч сумын мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд гэрээний дагуу ашиглуулж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан вакцины хөргүүрийг ашиглах гэрээг 2020 онд байгуулсан ба гэрээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 56 хөргүүрийг аж ахуйн нэгжүүд ашиглан 8 хөргүүрийг үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдээс татан авч сумын Засаг даргын Тамгын газрын мал эмнэлгийн тасагт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан вакцин хадгалах зөөврийн хөргүүр ашиглах гэрээний хугацаа 2021 онд дууссан боловч гэрээний сунгалтыг хийгээгүй байна.

2.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад төлөвлөгөөний дагуу малыг бүрэн хамруулж байгаа ч тарилга товлосон хугацаандаа хийгдэхгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Энэ хуулийн 6.4-т заасан дархлаажуулалтыг төлөвлөгөөт болон яаралтай хэлбэрээр зохион байгуулна", 9.2-т "Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална" заалтыг үндэслэн Мал

эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/47, 2022 оны А/28, 2023 оны А/19 тоот тушаалуудаар урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын товыг тус тус баталжээ.

Дээрх төлөвлөгөөг үндэслэн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга 2021-2023 онуудад дархлаажуулалтын хуваарийг сум тус бүрээр баталсан байна.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Малын бруцеллёзтой тэмцэх стратеги төлөвлөгөө”-нд заасны дагуу жил бүрийн 8, 9 дүгээр сард хийхээр төлөвлөн МЭЭГ-ын даргын 2021 оны А/179, 2022 оны А/166, 2023 оны А/179 тоот тушаалаар баталгаажуулсан байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.98-д заасныг үндэслэн шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах өвчнийг гоц халдварт өвчнөөр тодорхойлон тайлан, мэдээнд тусгасан байна.

Мөн хуулийн 9.39-г үндэслэн МЭЭГ-ын даргын баталсан 2021-2024 оны яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөө, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдээ, гоц халдварт болон халдварт өвчний мэдээтэй тулгахад 2021 онд Мөрөн, Цэнхэрмандал суманд гарсан шүлхий өвчний, 2022 онд Батноров, Баян-Адарга, Өмнөдэлгэр суманд гарсан бог малын мялзан өвчний үед тархалтын бүсийн малыг яаралтай дархлаажуулалтад хамруулаагүй байна.

Энэ нь өвчний дэгдэлтийн үе дарагдаж, халдварлах хугацаа дуусаж, хорио цээр тавигдсанаар яаралтай дархлаажуулалтад хамруулах малд зарцуулах вакцины захиалгыг аймгийн МЭГ-аас МЭЭГ-т хүргүүлээгүйтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд малын гоц халдварт өвчний гаралтыг сүүлийн 3 жилийн голомтын тоогоор авч үзвэл 2021 онд 17, 2022 онд 27, 2023 онд 36 голомт илэрч жил ирэх тутам гоц халдварт өвчний гаралт нэмэгдсэн байна. Нийт өвчлөлийн 42 хувийг хонины цэцэг, 27 хувийг шүлхий, 26 хувийг бог малын мялзан, үлдсэн 5 хувийг үхрийн арьс товруутах, хорт салст халуурал, гахайн африкийн мялзан эзэлж байна.

8 "Мал, амьтны гоц халдварт өвчин" гэж улсын хил хязгаараас үл хамааран богино хугацаанд тархаж, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хохирол учруулж, худалдаа, эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлөх өвчнийг хэлнэ

9 "Яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг тархвар зүйн судалгаа болон лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн гоц халдварт өвчний үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, бусад халдварт өвчний үед аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын дарга батална."

Дүрслэл 9: Малын гоц халдварт өвчний дархлаажуулалт, өвчин гаралтыг 2021-2023 онуудаар харуулбал




* Эх сурвалж: Аймгийн Мал эмнэлгийн газрын өвчлөлийн мэдээ

Гоц халдварт өвчин ихэссэнтэй холбоотойгоор 2022 онд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг улсын хэмжээнд бүх үхэр, гахай, сарлаг, цаа бугыг хамруулж хийснээр шүлхий өвчин 2023 онд гараагүй, 2023 онд бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг эрсдэл бүхий сумын том мал, бүх төл малд массыг хамруулж хийснээр бог малын мялзан, хонины цэцэг өвчин 2024 онд огцом буурсан байна.

Үүнээс үзэхэд гоц халдварт өвчнийг илэрсэн үед тархалтын бүсийг дархлаажуулах бус төлөвлөгөөт байдлаар аймгийн түвшинд бүх малыг дархлаажуулах нь илүү үр дүнтэй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоож, баг, хорооны Засаг дарга малчин, амьтан маллагчид зарлан мэдээлнэ" гэж заасан байдаг ба үүнийг бататгах зорилгоор аудитын явцад багийн Засаг даргаас тарилгад хамруулах хугацааны талаарх мэдээллийг авдаг уу? гэсэн санал асуулгыг цахимаар авахад 78 иргэн оролцож хугацаанд нь авдаг гэж 46 буюу 58%, хугацаа хоцорч авдаг гэж 9 буюу 11%, мэдээлэл авдаггүй гэж 23 буюу 29% нь хариулсан байна. Мэдээллийг ямар хэлбэрээр авдаг вэ? гэсэн асуултад оролцогчдын 83% нь утсаар, фэйсбүүк чатаар, хүний яриагаар дамжуулан авдаг гэж хариулсан байна.

Дүрслэл 10: Дархлаажуулалтыг зарлан мэдээлэх талаар иргэдээс авсан асуумж



* Эх сурвалж: Малчин иргэдээс авсан санал асуулга

Багийн Засаг дарга зарлан мэдээлэх арга хэмжээг зохион байгуулах ажлыг орчин үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулах шаардлагатай байна.

Төлөвлөгөөт дархлаажуулалтын гүйцэтгэлийг хянахад 2021 онд 2,286.6 мянган малыг дархлаажуулахаар төлөвлөж 98.5%-ийг, 2022 онд 1,970.2 мянган малыг хамруулахаар төлөвлөж 99.6%-ийг, 2023 онд 2,076.7 мянган мал хамруулахаар төлөвлөж 99.2%-ийг тус тус хамруулсан байна.

Хүснэгт 10: Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган толгой/


№	Өвчний нэр	2021 он			2022 он			2023 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Галзуу	200.2	190.2	95	84.3	83.1	99	55.0	53.9	98
2	Боом	225.8	213.1	94	118.2	122.8	104	130.0	131.5	101
3	Листериоз		-			-		10.0	10.0	100
4	Бруцеллёз	1386.8	1,376.4	99	1,126.7	1,119.8	99	1,286.7	1,275.2	99
5	Дотрын халдварт хордлого	222.0	220.6	99	222.0	221.2	100	290.0	289.1	100
6	Дуут хавдар	70.2	69.5	99	91.2	87.0	95	90.4	89.5	99
7	Цусан халдвар	180.6	181.2	100	326.0	326.3	100	213.0	211.1	99
8	Гахайн цусан халдварт	1.0	1.0	97	1.8	1.6	87	1.6	1.4	89
	ДҮН	2,286.6	2,251.9		1,970.2	1,961.7		2,076.7	2,061.7	

* Эх сурвалж: Аймгийн Мал эмнэлгийн газрын өвчлөл, дархлаажуулалтын мэдээ

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтад малыг бүрэн хамруулж байгаа боловч 2021 онд дуут хавдар, дотрын халдварт хордлого, 2022 онд боом, галзуу, дуут хавдар, дотрын халдварт хордлого, 2023 онд боом, галзуу, дотрын халдварт хордлого, бруцеллёзын дархлаажуулалт товлосон хугацаандаа хийгдээгүй байна.

Энэ асуудлыг тодруулахаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс цахимаар асуумж, судалгаа явуулахад 14 сумын 28 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хамрагдсанаас 15 нь буюу 53% нь халдварт өвчний тарилгын хугацаа давхацсанаас дархлаажуулалт товлосон хугацаандаа хийгдээгүй гэж хариулсан байна. Хонины цэцэг, бруцеллёз, боом, дуут хавдар зэрэг өвчний дархлаажуулалт хамгийн их хугацаа хоцордог гэж судалгаанд оролцогчид хариулжээ.

Дүрслэл 11: Дархлаажуулалтын талаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал асуулга



* Эх сурвалж: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс авсан санал асуулга

2.3. Дархлаажуулалтын үр дүнгийн хяналтыг хийж байгаа боловч технологийн хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д дархлаажуулалтын технологийн хяналтыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлэхээр заасан. Аймгийн Мал эмнэлгийн газар болон сумдын мал эмнэлгийн тасагт ажиллаж байгаа мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Мал эмнэлгийн ерөнхий газраас баталсан удирдамж чиглэлийн дагуу энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 04 дүгээр хяналт шалгалтын удирдамжийн 3.3.1-т төлөвлөгөөний дагуу малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд технологийн болон гүйцэтгэлийн хяналт хийж үр дүнг үнэлэхээр тусгасан байна. Удирдамжийн хүрээнд 18 сумын Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд нийт давхардсан тоогоор 1680 өрхөд үзүүлсэн мал эмнэлгийн арга хэмжээ, ажил үйлчилгээний чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан талаар тайлагнасан байна.

Мөн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан 2022 оны 01 дүгээр удирдамжийн 1 дүгээр хавсралтын 2.1.2-т яаралтай болон төлөвлөгөөт арга хэмжээг зохих заавар, технологийн дагуу хийгдсэн эсэхэд гүйцэтгэлийн хяналтыг тухайн мал эмнэлгийн үйлчилгээ хэрэгжиж байгаа газар дээр нь очиж, нийт гүйцэтгэлийн 30-аас доошгүй хувьд хянаж, биелэлтийг хангуулан улсын байцаагчийн дүгнэлт гаргахаар тусгасан байна.

Гэвч удирдамжийн биелэлтэд аймгийн хэмжээнд 18 сумын 78 үйлчилгээний нэгж мал эмнэлгийн яаралтай болон төлөвлөгөөт дархлаажуулалтын гүйцэтгэлд Мал эмнэлгийн тасгийн 15 улсын байцаагч хяналт тавьж ажилласан байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн бэлэн байдлыг Мал эмнэлгийн нэгдсэн систем дэх асуумжийн дагуу үнэлэхэд аймгийн дундаж оноо 48.6 хувьтай буюу стандартын хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн байгаа тул цаашид аттестатчилал хийх, стандарт шаардлага хангахгүй байгаа үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй талаар тайлагнасан байна.

Харин 2023 онд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/157 дугаар тушаалаар “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйл ажиллагаанд технологийн хяналт хийх удирдамж”-ийг баталсан байна. Удирдамжийн 3 дугаар хэсэгт харьяалах нутаг дэвсгэрийн малчин өрхийн 10-аас доошгүй хувьд орж дархлаажуулалтын явц, гүйцэтгэлийг газар дээр нь хянан үзэж, “Шалгах хуудас”-ын дагуу үнэлэлт өгөн, илэрсэн зөрчил дутагдлыг засах, арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна.

Удирдамжид зааснаар технологийн хяналтыг “Шалгах хуудас”-ын дагуу хийж гарсан үр дүнгийн мэдээг нэгтгэн 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлэхээр байсан боловч тайланг нэгтгэн явуулсан эсэх нь тодорхойгүй нотлох баримт байхгүй байна.

Хүснэгт 11: МЭГ-ын гүйцэтгэлийн хяналтын төлөвлөгөө, тайлан

д/д	Хугацаа	Хяналт хийх ажлын чиглэл	Тайлан
1	2021	3.3.1. МЭГ-ын даргын 2021 оны 03 сарын 01-ний А/48 тоот тушаалаар батлагдсан “Дархлаажуулалтын төлөвлөгөө”-ний дагуу мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд технологийн болон гүйцэтгэлийн хяналт хийх, шинжилгээ хийх, үр дүнг үнэлнэ.	МЭГазрын даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн мал эмнэлгийн арга хэмжээний явц гүйцэтгэлд хяналт тавих ажлын удирдамжийн хүрээнд 18 сумын МЭТасгийн мэргэжилтнүүд мал эмнэлгийн арга хэмжээ, ажил үйлчилгээний чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахад зориулж МЭГазраас 18 мэргэжилтэнд 230 литр шатахуун олгож нийт давхардсан тоогоор 1680 малчин өрх орж ажилласан.
2	2022	2.1.2. Зохих заавар, технологийн дагуу хийгдсэн эсэхэд гүйцэтгэлийн хяналтыг тухайн мал эмнэлгийн үйлчилгээ хэрэгжиж байгаа газар дээр нь очиж, нийт гүйцэтгэлийн 30-аас доошгүй хувьд нь хяналт хийх	Сумдын Мал эмнэлгийн тасгаас ирүүлсэн гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 тарилгын үйлчилгээний хөлсний материалыг мал эмнэлгийн нэгдсэн системийн гүйцэтгэлтэй хянаж тулган баталгаажилтыг бүрэн хийж ажилласан.
3	2023	Харьяалах нутаг дэвсгэрийн малчин өрхийн 10-аас доошгүй хувьд орж дархлаажуулалтын явц, гүйцэтгэлийг газар дээр нь хянах	Тайлан байхгүй

* Эх сурвалж: Аймгийн Мал эмнэлгийн газрын тайлан

Удирдамжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайлангаас харахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/457 дугаар тушаалаар баталсан “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ын 2.2 дахь хэсгийн хүрээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай болон төлөвлөгөөт арга хэмжээг өрхийн мал эмнэлгийн дэвтрийн хөтлөлт, цахим системийн бүртгэлтэй харьцуулан тулгалт хийн зөвхөн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Малын эмийн салбар зөвлөлөөр хэлэлцэж Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан тухайн вакциныг хэрэглэх зааврын дагуу зохих нас, хүйстэй малын тарих хэсэгт, баталсан тунгаар тарилгыг хийж байгаа эсэх, холбогдох санамжийг хэрэгжүүлж байгаа зэрэг технологийн арга хэмжээнд хяналтыг хийхгүй байна.

Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгүүлэх зорилгоор технологийн хяналтыг хийх “Шалгах хуудас”-ыг аймгийн хэмжээнд боловсруулан мөрдөх, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчаар дамжуулан тухайн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллах, цаашид энэхүү үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажиллах талаар төлөвлөгөөнд тусган ажиллах шаардлагатай байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7-д дархлаажуулалтын үр дүнгийн хяналтыг аймгийн мал эмнэлгийн лаборатори, шаардлагатай тохиолдолд улсын мал эмнэлгийн лаборатори хэрэгжүүлэхээр заасан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын захиалгаар, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори арга зүйг боловсруулан удирдан ажилласан бөгөөд, тандалтад шаардлагатай сорьцыг аймгийн Мал эмнэлгийн газар, сонгосон сумдын Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмчийн оролцоотойгоор цуглуулан ажиллажээ.

Хүснэгт 10: МЭГ-ын үр дүнгийн хяналтын судалгаа

д/д	Он	Өвчний нэр	Сумын тоо	Малчин өрхийн тоо	Малын тоо	Дархлаа тогтсон хувь	
						А хэвшил	О хэвшил
1	2021	Шүлхий	2	4	120		
2	2022	Шүлхий	18	54	324	80.2	96.9
3	2022	Бруцеллөз	3	45	1035	76.2	
4	2023	Шүлхий	18	54	324	83.9	84.3
5	2023	Бог малын мялзан	6	36	216	75	
НИЙТ			47	193	2019		

* Эх сурвалж: УМЭАЦЛ-ийн тайлан

2022 онд Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын дараах хяналт 3 сумын 45 өрхийн 135 тугал, 450 хурга, 450 ишгэнд цусны дээжийг авч Мал эмнэлгийн лабораторид шинжилгээ хийсэн. Шинжилгээгээр 111 тугал, 340 хурга, 338 ишиг эерэг дүн үзүүлсэн байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын дараах дархлааны идэвхийг 18 сумын 54 малчин өрхийн 324 үхрээс /үхэр, тугал/ цусны дээжийг авч улсын Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторид хүргүүлсэн. Үүнээс А хэвшилд 80.2, О хэвшилд 96.9 хувь дархлаа тогтсон гэсэн дүгнэлт гарчээ.

2023 онд бог малын Мялзан өвчний тандалтыг 6 сумаас санамсаргүй сонголтын аргаар сонгосон 36 малчин өрхийн 216 малаас цусны дээж авч УМЭАЦЛ-д хүргүүлсэн байна.

Шинжилгээний үр дүнд эсрэг бие үзүүлсэн байдал Галшар, Дархан сумдад 90-99 хувь, Хэрлэн сум 81-89 хувь, Баянхутаг, Норовлин сум 60-80 хувь, Цэнхэрмандал сум 20-33 хувь, Норовлин сумын 1 өрх огт дархлаажилгүй байна. Нийт дархлаажуулалтын хувь 75 хувьтай байна гэсэн үр дүн гарчээ.

Мөн 2023 онд Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын дараах дархлааны идэвхийг 18 сумын 54 малчин өрхийн 324 үхрээс /үхэр, тугал/ цусны дээжийг авч улсын Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторид хүргүүлснээс А хэвшилд 83.9, О хэвшилд 84.3 хувьд дархлаа тогтсон байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗАР**

Мал эмнэлгийн байр, Тариаланчдын гудамж, Сариг баг
Чингис хот, Хэнтий аймаг, 23119, Утас: 7056-3646
Цахим шуудан: khentii@vet.gov.mn

2024.11.18 № 242
танай 2024.11.14 -ны № 1012 -т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Манай байгууллагад 2024 онд хийгдсэн Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан.

Тус тайланд тусгагдсан зүйлсийг хүлээн зөвшөөрч байна.



ДАРГА *[Signature]* Н.АНХБАЯР

231193485

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- *Гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2022-2023 онд хамрагдвал зохих малыг төлөвлөж хийснээр 2024 оны хагас жилийн байдлаар шүлхий өвчин гараагүй, бог малын мялзан 91 хувь, хонины цэцэг өвчний гаралт 60 хувиар тус тус буурсан байна.*
- *Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хамрагдвал зохих бүх мал, амьтныг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулаагүй байна.*
- *Улс, орон нутгийн төсөвт малыг дархлаажуулах санхүүжилтийг 11,883.5 сая төгрөгөөр төлөвлөснийг 3,635.8 сая төгрөг болгон бууруулан баталснаар нийт малын 20.9 хувийг гоц халдварт, 8.4 хувийг халдварт өвчний дархлаажуулалтад хамруулж байгаа нь халдварт өвчингүй бүс болох зорилтыг хэрэгжүүлэх санхүүжилтийг бүрэн батлаагүйгээс шалтгаалжээ.*
- *Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр нөлөөтэй байдлыг үнэлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.*
- *Мал эмнэлгийн газраас малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын технологийн хяналтыг хэрэгжүүлээгүй нь дархлаажуулалтын үр дүн, ач холбогдлыг алдагдуулж байна.*
- *Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад төлөвлөсөн малыг бүрэн хамруулсан ч зарим халдварт өвчний дархлаажуулалт товлосон хугацаандаа хийгдэхгүй байгаа нь хугацааны давхцал, малчдын идэвхигүй байдал, багийн Засаг даргын хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлэхгүй байгаагаар холбоотой байна.*
- *Аймгийн төвөөс сум хүртэл 2021 онд 4,398.2 литр, 3,444.9 мянган тун вакцин, 2022 онд 6,347.2 литр, 3,821.4 мянган тун вакцин, 2023 онд 5,463.6 литр 4,531.4 мянган тун вакциныг зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн, 16 сумын Засаг даргын Тамгын газарт вакцин хадгалах өрөө, хөргүүр байхгүй нь вакцины чанарт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.*

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Аюурбунь-д

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болох зорилттой уялдуулан аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгах арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиглэлээр дүгнэлт, зөвлөмжийг өгч ажиллах,

Сумдын мал эмнэлгийн тасгийг малын халдварт өвчний эсрэг вакцин хадгалах хөргүүр хангах, аймгийн хэмжээнд зориулалтын тээврийн хэрэгсэлтэй болох ажлыг зохион байгуулах,

Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Н.Анхбаяр-т

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг цаг хугацааны давхцалгүй төлөвлөх, мэдээллийг малчдад цаг алдалгүй хүргэх ажлыг зохион байгуулах

Халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын технологийн хяналтыг тогтмол хийж, баталгаажуулан үр дүнг тооцож, тайлан мэдээллийг гаргаж журмын дагуу арга хэмжээг авч ажиллах

УАГ-ААР ДАМЖУУЛАН УЛАМЖИЛЖ МЭЭГ-Т ТАВИХ САНАЛ:

Салбарын хэмжээнд нэн шаардлагатай мэргэжилтний нөөцийг бүрдүүлэх, мал, амьтныг эрүүлжүүлэх бодлогын хүрээнд урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдвал зохих мал, амьтныг төлөвлөгөөт дархлаажуулалтад бүрэн хамруулах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn